

Alimaa (anonym) gives an interview to Irina Morozova in Khovd, in her office, in August 2012. The interview is in Mongolian. Some translation into Russian is provided.

- **Morozova:** то что я говорю... я историк, монголовед и занимаюсь историей Монголии 20 века, и я записываю устные истории людей, которые в те годы жили, их воспоминания. Если Вы нам немножко расскажите о тех временах далёких, мы были бы очень признательны.
- **Alimaa:** шууд асуугаад л, шууд ярилцаад л явчих уу?
- **Interpreter:** я уже говорил ей...
- **Alimaa:** асуух юм уу?
- **Interpreter:** асууя... хэдэн асуулт танаас асуучихья...
- **Morozova:** скажите, пожалуйста, где и когда вы родились? И кто были ваши родители?
- **Alimaa:** би 1959 онд энд одоо бодвол манай аймаг орон нутгийг зохих хэмжээгээр мэдэж байгаа байлгүй дээ, Мөнххайрхан суманд төрсөн. Аав ээж хоёр маань тэнд... 1959 он гэдэг чинь одоо эрт л болох гээд байна ш дээ, Мөнххайрханы сумын нутагт төрсөн тэгэхдээ Дуут сумын харъяат. Тэнд өсөж өндийсөн. Аав ээж хоёр маань.. аав маань сэхээтэн хүн байсан. Ээж маань ажилчин хүн байсан. Нийгмийн гарал сэхээтэн гэж явдаг.
- **Interpreter:** она родилась 1959 году на территории сомона Мөнххайрхан. Но она принадлежит сомону Дуут. Её родители были передовики, люди общества. Мама была рабочей.
- **Alimaa:** манайх чинь олон ястны нутаг гэдгийг мэдэж байгаа ш тэй, Ховдынх. Би бол урианхай хүн. Тийм Дуут сумын урианхай хүн.
- **Morozova:** расскажите о детстве, что вы о нём помните, о ваших родителях?
- **Interpreter:** хүүхэд насныхаа талаар ярина уу? Аав ээж одоо та хэд ямаршуу амьдралтай байв?
- **Alimaa:** Мөнххайрхан суманд төрсөн. Сумын бага сургууль төгссөн. Хүүхэд нас бол дүү нар маань цэцэрлэгээр хүмүүжсэн, тэр үед. Би нээх цэцэрлэгт байснаа санадаггүй юмаа. Тэгэхдээ цэцэрлэг гэдгийг сайн мэдэж байна. Тэгээд сургуульд орсон, тэгээд л аав ээждээ гэрийнхээ ажилд тусалдаг. Би бас айлын хоёрдохь том охин, гэрийнхээ бүх ажлыг хийдэг л тэгж л аав ээждээ тусалдаг. Бүх дүү нараа асарсан гээд л одоо

манайхан ярьдаг ш тэй. Бүх дүү нараа асарсан, бүх гэрийнхээ ажлыг хийдэг тийм л охин байсан ш дээ гэж ярьдаг, намайг. Тэгээд 4-р ангиа суманд төгсөөд, энэ аймгийн төвд ирж 8-р анги, 10-р ангиа төгссөн. Тэгээд тухайн үед Техникумд орсон.

- **Interpreter:** она была вторая девочка семьи. В семье есть старший брат, много младший брат и сестер. Она была хорошей нянкой этих младших братьев и сестер. И помогала родителям делать домашних дел. В сомоне окончила 4-ый класс, а потом окончила здесь 8-ой и 10-ый класс. Потом поступила в Техникум.
- **Morozova:** скажите, вы жили в самом сомоне в центре или в худоне в юрте?
- **Alimaa:** в сомоне в центре
- **Morozova:** в юрте или деревяном ...
- **Alimaa:** в юрте
- **Morozova:** у вас был... у родителей немного личного скота ... несколько коров?
- **Interpreter:** хувийн мал хөрөнгө гэж танай аав ээж хоёрт байв уу?
- **Alimaa:** тийм, бага зэрэг байсан. Яак... сарлаг саадаг. Тэгэхдээ социализмын үед ажлаа хийдэг, хөдөө жаахан сарлагтай. Тэрийг нь тэр үед Сүүн завод гэж байдаг ш тэй, сүүн тасаг дээр албан журмаар саалгадаг, тэгэхдээ хүнээр саалгаж өгдөг. Нэгдэлд сүү тушаадаг. Дараа нь сүүний норм гүйцэсний дараагаар, гэртэй авчирч саадаг. Тийм байсан. Сүүлд 90-ээд он гарахад цөөхөн хонь ямаатай болсон. Тэгээд тэр шугамаар аав ээж хоёр маань ялангуяа эрэгтэй хүүхдүүдээ гэрлэхэд нь мал тасалж өгч байсан. Одоо бол аав маань нас барсан, ээж маань 75, 76-тай хүн байна.
- **Interpreter:** её родители имели свои яки. В то время была государственная норма молока. И молочном заводе доили эти яки, а когда выполнялась норма тогда они обратно взяли яки для себя и доили. Потом с 90-х годов они начали пасти овец и коз, и когда именно женились сыновья родители им разделили и дали этих овец и коз им. Теперь отец умер, а её мама живёт и ей 76 лет.

- **Morozova:** скажите, пожалуйста, когда вы приехали из сомонного центра в Ховд, да... там 9-ый 10-ый класс, как я поняла, в школе заканчивать... скажите, вот у папы жизнь в Ховде, как тогда пришлось вам? было немножко тяжело или всё прошло очень гармонично?
- **Interpreter:** тухайн үедээ сумын төвд байж байгаад аймгийн төвд 10-р ангиас эхлээд ороход амьдрал тань хир өөрчлөлт гарсан бэ? Танд хэцүү санагдаж байсан уу эсвэл гайгүй байв уу?
- **Alimaa:** суманд 4-р ангиа төгсөөд тухайн үед аймгийн төвд сумын хүүхдүүд дотуур байранд ирж амьдарч байсан. Тэгэхдээ бараг сумаас тухайн үеийн олон хүүхдүүд ирж хамтдаа амьдарч байсан учраас яахав хичээл сурах, мэдээж дотуур байрны бэлэн хоол унд бүх юман дээр, гэрээ тухайн үедээ санадаг байсан байх. Яахав аймгийн төвд ирж сурах үүрэгтэй гэдгээ мэддэг байсан. Тухайн үедээ нэгдэл болвол тэр хүүхдүүдээ.. сум нэгдэл гэж байсан ш дээ тэр үед чинь, хүүхдүүдээ машинаар авчирч өгөөд, амралтаар нь машинаар аваад, гэрт нь хүргэж өгөөд л ингэдэг байсан. Яахав хүүхэд сумын төвөөс аймгийн төвд орж ирэхэд мэдээж арай л хөгжилтэй газар орж ирж байсан байх л даа.
- **Interpreter:** в то время из колхоза дали машины, чтобы привезти все ученики из сомона до аймака. И она вместе со своими сверстниками сюда приехала и начала учиться и жила в общежитии. Иногда она скучала по дому, но она знала, что должна здесь учиться. Но в общежитий была пища... из общежитии кормили их, и всё было нормально.
- **Morozova:** то есть, вам хотелось именно в Ховде учиться?
- **Interpreter:** в то время... она родом из этого и Ховд считается центром этого поэтому им обязательно здесь учиться.
- **Morozova:** как ваша жизнь складывалась после окончания школы?
- **Interpreter:** дунд сургууль төгссөний дараа таны аж амьдрал хэрхэн яаж үргэлжилсэн бэ?
- **Alimaa:** Сумаас ирээд энд чинь 8 жилийн сургууль гэж байсан. Аймгийн төв нэг 10 жилийн сургуультай, хоёр 8 жилийн сургуультай байсан. 8 жилийн сургууль төгсөөд бид чинь бас л сонголт хийж эхэлсэн. Тухайн үед ТМС гэж байсан, мэргэжлийн сургуульд явахуу, эсвэл техникумд

орохуу, эсвэл 10-р ангид орохуу гэсэн сонголт хийгдэж байсан. Тэгээд намайг Техникумд хувиарлахаар нь би Техникумд явахгүй, 10-р ангиа төгсөнө гэж шийдээд үлдэж байсан. Тэгээд 10-р ангиа төгсөөд конкурсанд ороод хуулийн дунд сургуульд явж байсан.

- **Interpreter:** в то время здесь были две школы 8-ми летние и одна 10-тилетняя школа. Ребята могли бы учиться в Техникуме после 8-ого класса. Но она решила окончить 10-ый класс и после этого она дала экзамен и поступила в Техникум правоведения. Там она училась.
- **Morozova:** то есть, средняя школа правоведения, - это после окончания обычной школы, да? А в какие это годы было?
- **Interpreter:** Та тэгээд тэр хуулийн дунд сургуульд хэдэн онд сурч байсан бэ?
- **Alimaa:** 77-80 онд гурван жил сурсан. Тухайн үед Техникумд хоёр жил сурцгаадаг байсан бол манай сургууль жаахан онцлоготой төрийн хуулийн чиглэлээр учраас 3 жилээр сурдаг. Тухайн үед хүүхдүүдэд стипенд гэж өгдөг байсан бол манай сургууль дээд сургуулиас илүү их стипенд өгдөг байсан. Бид 3 гурван жил сурч байсан.
- **Interpreter:** с 77-80 годов она училась. Это была специальная школа поэтому им по больше дали стипендию по сравнению с другими университетами того времени.
- **Morozova:** почему вы решили изучать именно право?
- **Interpreter:** чухам та ягаад хууль эрх зүйч болохоор шийдсэн бэ?
- **Alimaa:** миний одоо нөхцөл байдлын нэг хэсэг байсан даа. Тэгээд ч одоо тэр мэргэжлээрээ одоо хүртэл ажиллаж байна. Дараа нь би буцаж ирээд, сургуулиа төгсөөд сумынхаа төрийн нарийн бичгийн дарга гэж 20-хон насандаа томилогдож ирсэн.
- **Interpreter:** ... после техникума она стала работать в своём родном сомоне и работала государственным секретарём исполнительной администрации сомона, когда ей была только 20 лет.
- **Morozova:** расскажите о вашей работе тогда. Эти были 80-ые годы, когда вы работали этим исполнительным секретарём гос. администрации в вашем сомоне, расскажите тогда о жизни в вашем сомоне.

- **Interpreter:** таны ажиллаж байсан үе, тэр сумандаа ажиллаж байсан тэр ажил байдлын үе ямар байсан бэ?
- **Alimaa:** энэ үүргийг би 4 жил гүйцэтгэсэн. Яагаад гэвэл дараа нь би дахиад конкурс өгөөд их сургуульд явсан юм. Тэр хоорондоо 4 жил гүйцэтгэсэн юм байгаа юм. Тухайн үедээ энэ сумын нарийн бичгийн дарга гэдэг болвол сумандаа захиргаа талаасаа гуравдахь албан тушаал байсан юм. Тухайн үедээ 20 насандаа учраа мэдэхгүй охин энэ ажлыг гүйцэтгэж, их юм сурч байлаа.
- **Interpreter:** в то время это рабочее место считался третьей высокой должностью в сомоне. Он работала там 4 года и училась очень многому. Потом она поступила в Университет.
- **Morozova:** а какой факультет тогда?
- **Interpreter:** их сургуулийн аль факультетэд орсон бэ?
- **Alimaa:** нийгмийн ухааны факультет, хуульчийн анги төгссөн. Дахиад 5 жил сурсан. Нийтдээ 8 жил сурсан.
- **Interpreter:** тоже гуманитарный факультет, тоже правоведения, 4 года училась.
- **Morozova:** и вот за эти 4 года... то есть, вы решили, что просто хотите повысить свой уровень квалификации или вы уже не хотели работать исполнительным секретарём, почему вы решили дальше оттуда уйти?
- **Alimaa:** юу гэсэн бэ?
- **Morozova:** почему вы решили уйти после 4-х лет работы исполнительным секретарём? То есть, ваш опыт он там был, что происходило за эти 4 года?
- **Interpreter:** та тэнд нарийн бичгээр ажиллаж байсан, яагаад энэ ажлаараа ажиллаад байхгүй яасан бол, яагаад их сургуульд сурхаар болсон юм бэ?
- **Alimaa:** би дунд мэргэжлийг эзэмшсэн, одоо дээд мэргэжлийг эзэмших ёстой гэсэн зорилгыг өөртөө тавьсан.
- **Interpreter:** ей было среднее образование. Поэтому она поставила перед собой цель, чтобы получить высшее образование по этой профессии.
- **Alimaa:** тэгэхдээ хөдөө ажиллахад дунд мэргэжилтэй ч гэсэн сонирхолтой байсан. Би их зүйл сурсан.

- **Interpreter:** хотя она овладела среднее образование, ей было очень интересно работать в худоне.
- **Alimaa:** намайг 20-хон настай охин очиход энийг ингэдэг тэрнийг тэгдэг зааж өгөхөөсөө илүү угаасаа миний ажил бие дааж өөрөө шийдвэр гаргадаг ажил байсан.
- **Interpreter:** но её работа была такая работа, что она могла самостоятельно решать вопросы. Поэтому никто ей не посоветовал, она самостоятельно училась и работала.
- **Morozova:** какое было основное направление деятельности этого сомона? Оно было там в плане скотоводства или ещё какие-то предприятия... то есть, зачем вам приходилось следить и какие административные решения принимать?
- **Interpreter:** тухайн үед сумын байдал ямар байсан бэ? Мал аж ахуй дээр голлож анхаарч байсан уу эсвэл өөр нэг үйлдвэр үйлчилгээ явуулдаг тал дээр анхаарч байв уу, та ямар шийдвэр гаргаж байв?
- **Alimaa:** миний хувьд захиргааны тал дээр шийдвэр гаргадаг байсан. Гэхдээ тухайн үеийн нөхцөл байдал болвол хөдөө аж ахуй дээр суурилсан тэгээд хөдөө аж ахуйд ажилладаг малчид болон суманд ажиллаж, амьдардаг хүмүүсийн сургууль, эрүүл мэнд, бусад холбоо харилцаа, худалдаа үйлчилгээний юм социализмынхаа хэв загвараар хэвийн л явагдаж байсан, халамжийн.
- **Interpreter:** деятельность сомона основана на сельском хозяйстве и в большинстве случаев она делала административные решения. Она тоже работала и способствовала развитию деятельности сомона, состояние скотоводов и их здоровья, а также их образования.
- **Morozova:** а как потом вы учились в Университете Ховдийском, расскажите о тех студенческих годах?
- **Interpreter:** та Улаанбаатарт сурсан тийм ээ? Оюутны амьдралын талаар ярьж өгөхгүй юу?
- **Alimaa:** тийм. Бас л оюутны байранд 5 жил амьдарсан. Тэгээд л хичээл сургуульдаа онцгой анхаардаг байж дээ. Сургуулиас зохион байгуулсан олон нийтийн ажилд оролцдог, факультетдаа үйлдвэрчний хорооны дарга хийж байсан. 5 жил би амжилттай сурсан, онц сурсан.

- **Interpreter:** она училась в Улаанбаатаре 5 лет и жила в студентском общежитии. И большое внимание уделяла обучению и была отличницей. И она очень активно участвовала в мероприятиях, которые организован Университетом. И ещё она была начальником Профсоюза на факультете.
- **Morozova:** а ещё расскажите что-нибудь о неформальной студентской жизни... как вы собирались с разными студентами, где, что вы обсуждали, какая у вас была мода, к чему, в основном, все стремились?
- **Interpreter:** сургуулиас зохиож байгаа арга хэмжээнээс гадна та хэд хувиараа тухайн үеийн оюутны амьдралд хоорондоо юу ярьдаг, ямар зүйл хүсч мөрөөддөг, юу шүтдэг биширдэг зүйл юу байсан юм бол?
- **Alimaa:** тухайн үедээ бие бол харьцангуй 4 жил ажилласан, 18-тай хүүхдүүдээс жаахан ахмад. Тэгэхдээ манай ангид надаас илүү ахмад хүүхдүүд их байсан. 10-насаар ах байсан. Бид нар ерөнхийдөө оюутны хүсэл мөрөөдөл бол ангийн тухайд бол өөр өөр ш дээ. 18, 20, 30 хэд хүрсэн хүмүүс сурч байсан. Бид тэгэхдээ гол нь сайн сурах ёстой, хичээх ёстой, нийгмийн үүрэг хариуцлага өөрөө үүрч сурах ёстой гэсэн хүсэл эрмэлзэлтэй байсан. Хоёрдугаарт бид залуу байлаа. Залуу байхад хүсэл мөрөөдөл янз бүр байсан байх. Миний тухайд эмэгтэй хүн байсан. Сурч байхдаа гэр бүлээ өсгөсөн шүү дээ, их сургуульд. Нөхөр маань сумандаа багшилж байсан, тэр үед сурч байхдаа хүүхдээ гаргасан. Тэгээд миний тухайд бол тийм замаар гэр бүл гэсэн зүйл эрхэм болж ирсэн. Тэгээд сургуулиа төгсөөд сумандаа эргэж ирсэн дээ.
- **Interpreter:** во время её учения она родила сына. А его муж работал в сомоне в качестве учителя. По сравнению с сокурсниками она была немножко старше. И ещё другие старшие люди тоже учились вместе с ней. И поэтому они думали, что мы должны учиться и должны сознавать долг. Потому после окончания университета она сразу приехала сюда и так начали жить.
- **Morozova:** значит, ваш ребёнок родился в Улаанбаатаре в то время. А кто вам потом помогал? Потому что ребёнок маленький, надо ходить в Университет, я могу себе представить, что это было не просто, кто вам помогал?

- **Interpreter:** за тэгэхээр та хүүхдээ гаргачихсан байдаг. Оюутан байхдаа хичээлдээ явмаар байдаг, хүүхдээ асармаар байдаг. Бас жаахан хэцүү байж болзошгүй. Та үүнийг яаж хэрхэн зохицуулдаг байсан бэ?
- **Alimaa:** хүүхдээ аав нь, тэгээд миний ээж дүү нар тусалсандаа. Тэгээд ямарч байсан сургуулиа засварлаагүй төгссөн дээ.
- **Interpreter:** тэд хотод ирсэн байсан уу?
- **Alimaa:** үгүй. Би өөрөө амралтаараа байнга ирдэг байсан. Энд хүүхдээ аавд нь үлдээгээд. Ээж дүү нар мань түүнд тусалсандаа.
- **Interpreter:** она приехала с ребёнком здесь и оставила его с отцом. Её мама и младшие сестры помогали здесь. Она постоянно приехала сюда и жила с семьёй во время студенческого отдыха.
- **Morozova:** скажите, что вы делали как начальник Профсоюза в Университете и как вас выбрали на эту должность?
- **Interpreter:** үйлдвэрчний эвлэлийн хорооны даргаар ажиллаж байхдаа та юу хийдэг байсан бэ? Таныг хэрхэн сонгосон бэ?
- **Alimaa:** факультетед оюутны хурлаар сонгож байсан. Үйлдвэрчний байгууллагын зорилго нь өөрөө тэр сонгосон хүмүүсийнхээ эрх ашгийг хамгаалахад чиглэгдэж байсан. Тиймэрхүү л ажлыг хийж байсан. Захиргаанд хүсэлт тавих, оюутны амьдралыг ингэмээр байна, тэгмээр байна, одоо ийм шаардлагатай байна, асуудлыг шийдвэрлүүлэхэд чиглэгдэж байсан. Тэгэхдээ тийм том албан тушаал биш шүү дээ. Зүгээр л факультетын хүрээнд шийдэгддэг байсан.
- **Interpreter:** это была не так большая должность. Из собрания студентов она была выбрана и она работала. Этот профсоюз должен работать за права студентов. Она передала желания студентов или жалобы в администрацию Университета, чтобы они решили.
- **Morozova:** это вот очень интересно. Какие тогда у студентов были пожелания и жалобы, то есть, ущемлялись ли их права в каких-то да... сферах?
- **Interpreter:** танай тэр оюутнууд ямар хүсэл гомдол гаргаж байсан бол санаж байгаа болов уу? Голчлон ямар шаардлага тавьдаг байсан бэ?
- **Alimaa:** за гайгүй дээ ерөнхийдөө. Тэгэхдээ бас анги хүйтэн байна ч гэдэг юм уу, тэгээд яахав багш нар бол цагтаа хичээлээ заачихдаг байсан. Анги

жаахан хүйтэн байна гээд, өөр юу байлаа даа, өөр нээх онцын юм байгаагүй байх аа. Нээх проблем бага байсан.

- **Interpreter:** не было серьёзных проблем. Но были проблемы такие как, - студенты жалуются о том, что в классе холодно, и нужно решить эту проблему и т.п.
- **Morozova:** значит, в каком году вы вернулись в Ховд, когда закончили обучение?
- **Interpreter:** тэгээд та хэдэн онд Ховдод ирж байсан бэ?
- **Alimaa:** 84 онд ирээд 89 төгсөөд тэгээд ирсэн.
- **Interpreter:** та төгсөнгүүтээ шууд ирсэн үү?
- **Alimaa:** төгсөнгүүтээ л ирсэн.
- **Interpreter:** 84 году она приехала, здесь 89 году окончила Университет и сразу приехала в Ховд.
- **Morozova:** в каком месяце, как помните, вы приехали сюда?
- **Alimaa:** намайг 4-р курст байхад энэ аймгийн өмгөөлөгчдийн зөвлөлийн даргаар томилчихсон байсан. 5-р курсээ төгсөөгүй байхад намайг урьдчилаад томилчихсон байсан. Шууд тэр албан тушаал дээр ирсэн.
- **Interpreter:** хэдэн сард ирсэн бэ?
- **Alimaa:** гэхдээ 89 оны 7-р сард ирсэн л дээ.
- **Interpreter:** когда она училась в 4-ём курсе, её заранее выбрали начальником союза адвоката этого аймака. Она приехала сюда в июле 89 года.
- **Morozova:** расскажите, - значит, ваша студенческая жизнь, - она выпала на период перестройки. И вот мы знаем о тех первых студенческих движениях и демонстрациях. Правда, они, демонстрации, начались уже после того, как вы покинули Улаанбаатар. Но вот вы об этом что-нибудь помните?
- **Interpreter:** тэгэхээр таныг яг оюутан болоод төгсөж байх сүүлийн үед ардчилал үе гарч байсан ш тэй, өөрчлөн байгуулалт гээд. 89 онд жагсаал болсон. Тэгэхдээ таны төгссөний дараа тэр жагсаал болсон байна. Тэгэхээр тэр талаар та юу гэж бодож байна вэ?
- **Alimaa:** тэр талаар бол тухайн үедээ ер нь би оюутан байхад эрдэм шинжилгээний хуралд илтгэл бэлтгэх, хуралд оролцох ажилд бас их

оролцдог байсан. Тухайн үедээ яахав манай факультет оюутнуудын дунд бол ардчилалын ойлголтоор их эрдэм шинжилгээний хурал болдог байсан. Би хүртэл “Төвийн ардчилал” гэсэн сэдвээр Улаанбаатар хотын хэмээнд эрдэм шинжилгээний илтгэл тавьж байсан. Манай хичээл заадаг Андрей Плотникс гэж багш байсан. Тэр удирдаад би лав өөрийнхийгөө сайн санаж байна тийм илтгэл тавьж, ардчилалын талаар илтгэлүүд 88,89 ондоо. Яг бол оюутны хүрээнд. Түүнээс биш жагсаал болоогүй, тухайн үедээ, бид нарын дараа болсон ш дээ.

- **Interpreter:** в то время, 88-89 годах, она много раз участвовала на конференции. По теме демократизация она выступала с многими докладами на конференциях. Её преподаватель Андрей Плотникс вёл их. Она сама не участвовала на демонстрации.
- **Morozova:** А вы можете вспомнить, что вам тогда о демократии этот преподаватель преподавал, и о чём были ваши выступления, ваши доклады и как вы это тогда обсуждали на докладе там, после доклада.... какие были там основные пункты, моменты?
- **Interpreter:** тэгэхээр тэр багш одоо та хэдэд ардчилалын талаар юу заадаг байв? Тэгээд ардчилалын илтгэлдээ та яг юуны тухай бичиж байв? Та хэрвээ санаж байвал...
- **Alima:** манайд гадаадын мэргэжилтэн багш нар хичээл заадаг байсан. Оросоор хичээл заадаг байсан учраас ардчилалын талаар бас ойлголтууд байсан. Тэгэхдээ одоогийн хэмжээнд сонгодог хэмжээнд ойлголтгүй байсан юм шиг байгаа юм. Тэгэхдээ төрд бол ардчилал байх ёстой. Ардчилал байхын тулд хүнд суртал байх ёсгүй, шийдвэр гаргахад олон нийтийн оролцуулах ёстой гэдгээ санаж байна. Би судалгаа хийж, бичиж байсан болохоор.
- **Interpreter:** Чуть-чуть она вспомнит, что преподаватель сказал им, что демократизация должна быть в стране. Но это понятие о демократизации не так высоком уровне развивался в то время как сегодня, но в своём уровне они приготовили свои доклады.
- **Morozova:** а вот очень интересно, когда вы покидали Улаанбаатар в июле 89 года, вы тогда могли предположить что совсем скоро там начнутся такие демонстрации и пройдёт меньше года, как правительство

уйдэт в отставку? Когда вы уезжали, у вас было такое впечатление, что это всё назревало?

- **Interpreter:** тухайн үед таныг нашаа ирж байхад та удахгүй энэ оронд ардчилал гарч ирэх юм байна, төр засаг маань өөрчлөгдөх юм байна гэсэн ойлголт бодол танд төрч байв уу?
- **Alimaa:** нээх гүнзгий төрж байгаагүй. Зүгээр ер нь болвол ЗХУ-д өөрчлөн байгуулалтын асуудал ярьж байсан тул оюутнуудын дунд энэ талаар мэтгэлцээн өрнөдөг байв. Тухайн үедээ бид нарыг байхад Балдорж гэж нэртэй сэтгүүлч маань “Хуулийн тавцан”, “Манай Хөвсгөл нуур” хурц нийтлэлүүд гардаг байсан. Хуулийн ангийнхан иймэрхүү юманд татагдан оролцдог, мэтгэлцээн маргаанд оролцдог, янз бүрийн радио телевизийн нэвтрүүлэгт оролцдог байв. Ер нь бол зөв, буруу, тэгэх ёстой ингэх ёстой гэсэн юманд манайхан их оролцдог байв. Тэгэхдээ өөрчлөн байгуулалт бид нарт хэрэгтэй юм байна гэсэн ойлголт байсан. Тэгэхдээ шууд ингээд өөрчлөгдөнө гэсэн бодол байгаагүй.
- **Interpreter:** студенты между собой разговаривали про демократизации и о перестройке в Советском Союзе. Они проводили дискуссий о перестройке в Советском Союзе. Балдорж, наш знаменитый журналист который написал статью об этом, и студенты прочитали в газете. Но они не думали, что в таком быстром темпе у нас победит демократизация. Они думали, что нам нужна перестройка, но не думали, что это происходит так быстро.
- **Morozova:** когда вы вернулись в Ховд, вы сразу начали работать здесь помощником адвоката аймака? Или ещё какая...
- **Interpreter:** та Ховдод ирэнгүүтээ өмгөөлөгчөөр ирж ажилласан уу?
- **Alimaa:** тийм. Өмгөөлөгчөөр эхэлж ажилласан.
- **Interpreter:** она сразу стала работать адвокатом.
- **Morozova:** и вот вы приехали. Здесь стали развиваться события, здесь была первая студентческая демонстрация, вы помните этот момент? Эти дни вы запомнили?
- **Interpreter:** тэгэхээр таныг ирэхэд энд нэг Ховдын оюутны жагсаал болж байсан гэсэн. Тэр жагсаалыг та санаж байна уу? Тэр үеэр юу болсон бэ?

- **Alimaa:** санаж байна. Энэ жагсаал 89 оны 12 сарын сүүлээр болж байсан. Би өмгөөлөгч хийж байсан... Жагсаал хийж байна, дарга нарт шаардлага тавьж байна гэсэн мэдээлэл авч, харж байсан. Манай гэрт ч ойрхон байсан. Тэр үед би жагсаалаас холхон зүгээр иргэдэд тусалдаг ажил хийж байсан Ер нь бол хөндлөнгийн ажиглагч байсан.
- **Interpreter:** она знала об этом в то время. Но она думала, что нужно помогать людям как адвокат. И её дом был ближе к этому. Поэтому она посмотрела на демонстрацию.
- **Morozova:** расскажите, вот тогда какие у вас были дела как у адвоката, в основном, кого вам приходилось защищать и по каким делам?
- **Interpreter:** тухайн үед таны ажил төрөл ямар байсан бэ, ямар ямар хүн өмгөөлж байв?
- **Alimaa:** би нөгөө гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн өмгөөлөгчөөр ажиллаж байсан. Би чинь өмгөөлөгчөөр 1989-2001 хүртэл ажилласан. Үндсэндээ 11 жил ажилласан. Тэгээд тухайн үед одоо 1989-2001 он хүртэл Ховд аймагт хүн амины хэрэг үйлдэгдэхэд тэр бүх хэргийг би өмгөөлж байсан. Өөрөөр хэлбэл, өмгөөлөгчөө сонгодог байхгүй юу. Тийм зарчим үйлчилж байсан. Ер нь гэмт хэрэг үйлдсэн хүмүүсийн шүүх хуралд өмгөөлөгчөөр оролцдог байлаа.
- **Interpreter:** когда она работала адвокатом с 1989-2001года, в большинстве случаев она была адвокатом криминалистов, в большинстве случаев те люди, которые убили людей, обращались к ней, чтобы она защитила их. В то время люди сами выбирали своих адвокатов.
- **Morozova:** интересный такой вопрос... вот уровень преступности в какой год из этих лет был наибольший уровень преступности, поскольку как адвокат она, наверно, эту статистику помнит? Увеличилась ли преступность с 90-ого и когда она начала снижаться?
- **Morozova:** а вот когда был самый высокий уровень преступности? Она увеличилась, преступность, в 90-х годах?
- **Interpreter:** ямар гэмт хэрэг хамгийн ихээр үйлдэгдэж байв? 90-ээд оны үед гэмт хэргийн тоо өссөн үү?

- **Alimaa:** гэмт хэргийн тоо өссөн. Хүн амины хэрэг гарч байсан, ер нь бүх хэрэг их өссөндөө. Тэгээд хулгай, сүүлдээ залилан их байдаг. Энэ хоёр л ихэнхдээ байдаг.
- **Interpreter:** почти все разные криминали выросло 90-х годов. Большинство из них занимало место воровство и обман.
- **Morozova:** понятно. Это меня всегда поражало, но до сих пор для меня работа адвоката является некой загадкой. Если к вам приходит человек, который совершил убийство: ну, допустим, его неправильно обвинили и тогда я понимаю, как вы защищаете. А вот объясните... вот что вы чувствуете, что вы делаете, если к вам приходит человек, и очевидно, что он убил, но он просит, чтобы вы его оправдали. Как это происходит? Мне всегда это было немного не понятно в работе адвоката.
- **Interpreter:** тэгэхээр өмгөөлөгчийн ажлыг хувийнхаа талаас энэ хүн их гайхдаг гэж хэлж байна. Яагаад гэвэл хэрвээ нэг хүн хүн алсан мөртлөө, хүн алсан нь тодорхой байхад өөрийгөө өмгөөлүүлэхгээд байдаг. Энэ тохиолдолд та юу хийдэг байсан бэ? Яадаг байсан бэ?
- **Alimaa:** нэгдүгээрт, хууль зүйн үндэслэл нь тэр хүн шүүхийн өмнө зогсож байгаа бол буруу зөвөө шийдүүлэхийн тулд цаана нь яллагч тал байгаа тохиолдолд өмгөөлөгч тал байх ёстой хуулийн заалттай ш тэй. Хоёрдугаарт тэр хүн эрхээ хамгаалах ёстой. 90-ээд он гарангуут хүний эрхийн асуудал гарцаагүй орж ирсэн.
- **Interpreter:** во-первых, в законе так указали, что... судья решил осудить преступника, то этот преступник должен взять адвоката. Если есть обвинитель, то тогда должен быть адвокат. Во-вторых, с 90-го года начал говорить свобода и права людей. Поэтому человек имеет право взять адвоката.
- **Morozova:** понятно. А скорее всего после того, как здесь произошли эти события, в Ховде демонстрация, что изменилось в жизни города и в вашей личной жизни, если что-то изменилось?
- **Interpreter:** Ховдод ардчилал гараад, Ховдынхны амьдралд өөрчлөлт гарсан уу?
- **Alimaa:** ерөөсөө өөрчлөлт хөдөлгөөн бүх юм нь адилхан ш тэй. Ховдод бол 90-ээд оны эхэн үед ямарч бэлтгэлгүй ороод нилээд хүндэрсэн. Яваа

яваандаа өөрчлөлт гарсан нь харагдаж байгаа. Шаал хоёр өөр ертөнцөд ажиллаж, амьдарч байна ш тэй, миний хувьд жишээ нь. Урьд нь тиймэрхүү байсан бол одоо ингээд нэг талаас чөлөөтэй юм шиг нөгөө талаас замбараагүй юм шиг. Тэгэхдээ тэр дундаас зөв замаа олж авах, зөв хандлагаа олж авах боломж нь нээгдчихсэн байгаа.

- **Interpreter:** она работала в двух обществах. С одной стороны, состояние общества беспорядочно, с другой стороны, люди имеют свободу. Она думает, что здесь человек должен найти свою правильную направленению. И ещё в начале 90-х годов трудно было... вещи стали редко ... во всех странах так было.
- **Morozova:** а как вы выживали во время карточной системы и этих всех экономических сложностей? Как вот ваша семья справлялась?
- **Interpreter:** карты систем орсон үед таны аж амьдрал ямар байв? Таны гэр бүлийн аж амьдрал хир байв?
- **Alimaa:** карты системд орсон. Аз болоход богино хугацаанд байсан шүү. Тэгээд бид яахав зохих хэмжээний цалинтай ажилтай байсан. Бид хоёр төрийн ажил хийдэг байсан учраас. Гэхдээ мөнгө байгаад бараа нь байхгүй байсан. Одоо бол бараа нь элбэг мөнгө нь байхгүй бас тулгарч байна. Тэгэхдээ сүүлийн үед бол харьцангуй гайгүй болсон. Аль аль нь боломжтой болж байгаа.
- **Interpreter:** в то время они двоём с мужем работали в государственных учреждениях и получали зарплату. Но в то время есть деньги, но нет товары. Сейчас, наоборот, есть товары, денег мало.
- **Alimaa:** Мөнгө нь бага байна бараа нь их байна. Зарим нь яахав бизнес хийж байгаа хүнд бол тэр нь болж байна. Бид нар төрийн албан хаагч учраас цалин бага гэдгээрээ хүссэн хэмжээгээрээ амьдрах боломж муутай гэхэд хайшаа ч юм, тэгэхдээ олон жил ажиллаж амьдарч байсан туршлагаараа бол тэгж их онцгойрохгүй ч гэсэн ямарч байсан зөв авч явж байна.
- **Interpreter:** сегодня те люди, которые занимаются бизнесом, у них жизнь нормально, а для тех, которые работают в государственном учреждений, зарплата в среднем уровне, не так мало. Но сегодня цена

долларов повысилась и иногда их зарплата не хватает. Но по опыту жизни сегодня они организуют свою жизнь на нормальном уровне.

- **Morozova:** а сколько у вас всего детей?
- **Alimaa:** хоёр. Нэг охин, нэг хүүтэй.
- **Morozova:** но сейчас первый ребёнок, наверное, большой. Они сейчас учатся или уже... кто-то работает?
- **Interpreter:** одоо хэн нь ямар мэргэжилтэй хүн болсон бэ?
- **Alimaa:** хүүхдүүд үү? Миний хүү одоо барималч- зураач мэргэжилтэй. Одоо аймгийн музейд ажиллаж байна. Охин бол гадаад харилцааны ангил-орос хэлний багш-орчуулагч хоёр мэргэжлээр.
- **Interpreter:** его сын скульптр и художник. Он работает в музей. Её дочка имеет профессию английского и русского языка по международным делам.
- **Morozova:** скажите, среди адвокатов здесь и судьев, прокуроров как много женщин, какой процент женщин?
- **Interpreter:** эрэгтэй эмэгтэй хүмүүсийн харьцаа нь ямар байгаа бол?
- **Alimaa:** шүүхэд бол эмэгтэй нь илүү. Прокурорт тэнцүү байгаа байх. Цагдаад мэдээж эрэгтэй нь илүү байгаа байх гэх мэт хуулийн байгууллагад.
- **Interpreter:** в прокуратуре равное число женщин и мужчин, а в полиций мужчин много, а в суде женщин много.
- **Morozova:** а что вы вспоминаете самое хорошее, какой период вашей жизни? из воспоминаний... какое самое тёплое?
- **Interpreter:** таны амьдралд хамгийн сайхан гоё үе байсан, үе тэр хэзээ байсан бэ?
- **Alimaa:** нээх муухай үе байсангүй. Хамгийн сайхан үе гэх юм бол 90-ээд онд улс нийгэм маань хэцүү үе ч байсан ч гэсэн би өмгөөлөгч хийгээд, өмгөөлөгч хийхдээ би тэр хүнийг ялгүй гаргахдаа биш ерөөсөө шудрага ёсыг эрхэмлэх нь дээр гэсэн тэр үзэл бодлоор энэ арван хэдэн жил өмгөөлөгч хийхдээ их чадваржсан. Их дуртай цаг үе маань байсан. Яагаад гэвэл тэр үед би ажлаа хийж чадаж байсан, туршлага олж авч байсан, нийгэмд нэр хүндтэй болсон.

- **Interpreter:** вообще, у неё не было плохого время в жизни. Но с 90 до 2001 года она работала в качестве адвоката. Она могла работать и выполнять свою работу. И она могла получить много опыт. Она работала не для спасения преступников, но она всё было справедливо сужденно. Это было для неё самое прекрасное время. Она считается одной из лучших адвокатов в то время и до сих пор так считается.
- **Alimaa:** 90-ээд оноос хойш өмгөөлөгчөөр ажиллаж байлаа. Тэгээд хүний эрхийн тухай ойлголт, хандлагатай болж, хүний эрхийг эрхэмлэх тэр их боломжийг олж, сурч мэдэж, одоо тэр чиглэлээр ажиллаж байгаадаа баяртай байгаа.
- **Interpreter:** 90-х годах она получила понятие о правах людей. Она оценила и поддержала права людей. Это её задача и работа сейчас. И таким образом до сих пор она работает.
- **Morozova:** а это очень благородная задача. Скажите ей.
- **Interpreter:** энэ бол таны зөв сайхан шийдвэр байна гэнээ.
- **Alimaa:** тэгээд хичнээн ч би орон нутгийн захиргаанд ажилладаг ч гэсэн хуулийн мэргэжилтэн ш тэй би. Гэхдээ Би хүний эрхийг хариуцсан ажилтан байхгүй юу. Тэрүүгээр би хамгийн чухал ажил хийж байгаа гэсэн ойлголттой явдаг. Хүмүүст ч, жирийн иргэдэд ч би яг тэр чиглэлээр тусалдаг.
- **Interpreter:** главное, что до сих пор она работает согласно своей мечте, сейчас она профессиональный юрист и работает по вопросам прав граждан.
- **Morozova:** вот ещё такой вопрос не могу не задать. Вот вы, поскольку работали адвокатом здесь в администрации, вы, может быть, помните вот с этим переходом к демократии сменилось аймочное руководство, новые начальники пришли или остались старые?
- **Interpreter:** во время когда?
- **Morozova:** но вот 90-ые годы, во время этих демократических преобразований, когда ушло правительство в отставку. Сменилось ли тогда руководство ?

- **Interpreter:** 90-ээд оны үеэр өөрчлөн байгуулалт болж байсан ш тэй. Тэр үед хийж байсан аймгийн дарга нар өөрчлөгдсөн үү? Социализмын үед аймгийн дарга хийж байсан хүмүүс ардчилал гарах үед өөрчлөгдсөн үү?
- **Alimaa:** шууд өөрчлөгдөөгүй. Тэгэхдээ бол ажлаа хийгээд л. Одоо үеийг бодвол тэр үеийнх нь илүү албан үүрэгтэй хариуцлагатай байсан. Тэр чанар нь бас хэрэгтэй. Одоо цагийн шинэ хандлагатай уялдуулахад зарим нь юм хоцрогдсон тийм юм ажиглагддаг. Одоо бол арай өөр л дөө, социализмын арга барил байхгүй, тэр үеийн хүмүүс тэтгэвртээ гарах нь гараад ерөнхийдөө тэгээд шинэчлэгдсэн. Гэхдээ одоо бол хоёр намын систем байгаа. Тэр хүрээндээ бол энэ улс төрийн бодлогоос юм шалтгаалж байгаа. Тэгэхдээ тэргүй ардчилалын замд эргэлт буцалтгүй орсонд хүлээн зөвшөөрч байгаа. Удирдлагын арга барилыг өөрчлөхийн тулд тэр улсууд ч гэсэн өөрөө юм хийж, дуудаж сургаж байгаа. Орон нутагт ирээд одоо ажлын хариуцлага гэдэг юман дээрээ дутагдалтай байгаа юмуу гэж бодож байдаг, одоо энэ дарга нарыг, удирдлагуудыг, ер нь хэн ч байсныг. Бусдын өмнө хариуцлага хүлээхгүй болж байгаа.
- **Interpreter:** руководство изменили, но не сразу. Те начальники, которые были при социализме, продолжали работать, и у них были однообразные методология работы. В конце 90-х годов сделали изменения и старые работники ушли на пенсию. Сейчас они думают, что наша страна идёт по демократической линией.
- **Morozova:** можно спросить, вы верующий человек?
- **Interpreter:** та шүтлэгтэй хүн үү?
- **Alimaa:** нээх шүтлэг байхгүй.
- **Interpreter:** не верующий человек.
- **Morozova:** спасибо большое за ваше интервью и я с восхищением вижу, что вы следовали вашей цели в жизни... с глубоким убеждением. Большое спасибо за ваш рассказ. Если можно сфотографировать ...
- **Interpreter:** за тэгээд таньтай ярихад тааламжтай байлаа. Би таныг хараад бахархаж байна, та насан туршдаа өөрийнхөө хүсэл мөрөөдлийнхөө дагуу ажиллаж амьдарч байгаа юм байна. Таны зургийг авч болох уу?

- **Alimaa:** За би бас ингээд хичнээн одоо юу гэдгийн хоёр социализмын арга барилаар сурч, ардчилалын үед ажиллаж байгаа ч гэсэн, аль болохоор цаг үетэйгээ зохицож, шинэ хандлагыг эзэмшиж сурч, тэрлүү ингэж явж байгаа. Би одоо 50 гарсан хүн ш тэй. Магадгүй удахгүй намайг шинэ удирдлагууд тэтгэвэртээ гарахыг шаардаж магадгүй. Миний бие эрүүл байвал би хүний төлөө ажиллах болно. Миний зургийг авах ч одоо тийм хэрэгтэй юу?
- **Interpreter:** поскольку она получила профессию при социализме, но она постаралась работать в демократическом обществе. И у неё лет за 50. И может быть из администрации требовать её уйти на пенсию. Если у неё есть умение работать в демократическом обществе, она дальше будет работать для защиты прав людей.
- **Morozova:** кажется, я больше доверяю людям, которые получили образование в социалистическом времени, нежели после 90-го года.
- **Interpreter:** тэгэхдээ социализмын үед боловсрол эзэмшсэн хүмүүс бол ардчилалын үед боловсролтой болсон хүмүүсээс илүү чанартай байдаг гэнээ.
- **Alimaa:** тийм. Тэр утгаараа би байгаа болов уу гэж бодож байна. Социализмын үед авах юм байгаа. Зүгээр тэр системийн хувьд өөрчлөх шаардлагатай боловч тэр ажлын хариуцлага, бусдын өмнө үүрэг хүлээх зэрэг асуудал тун хэрэгтэй байгаа. Одоо үгүйлэгдэж байгаа.
- **Interpreter:** В то время обязанность была очень хорошо, но сейчас исчезла ответственность.
- **Morozova:** Да... это так. В России тоже так.
- **Alimaa:** баярлалаа амжилт хүсье. Хол явж байгаа байна.
- **Interpreter:** она тоже очень благодарна и желает удачи Вам.
- **Morozova:** Спасибо.